



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 19 он 01 дугаар
сарын 24 ны өдөр

Дугаар ХЭГ/207

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
С.ЭРДЭНЭ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан Таны асуулгын хариуг үүгээр хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт: 2. хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Т.ЗАНДАНШАТАР

0000924

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН С.ЭРДЭНЭЭС МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД ХАНДАЖ ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ

Асуулга 1. Дэлхийн зах зээл дээрх нүүрс, зэсийн үнэ ханш огцом унасан 2012 онд АН-ын Засгийн газар бонд босгон иргэдээ байртай, компаниудаа үйлдвэртэй, улсаа дэд бүтэцтэй болгож, нийт эдийн засагтаа Монголдоо үлдэх, ирээдүйд ашиг, үр өгөөжөө өгөх өмч хөрөнгө, хуримтлал бий болгож чадсан билээ. Бид 4 жил хүрэхгүй хугацаанд 86 мянган өрх шинээр байранд оруулж, 96 мянган ажлын байр бүхий барилгын салбар, бусад олон дагавар салбаруудын өсөлтийг дэмжин ажилласан. Мөн 3,405 км хатуу хучилттай зам барьж, нийт хатуу хучилттай замаа 2.2 дахин өсгөж чадлаа. Эрчим хүчний үйлдвэрлэл 25 хувь өсөж, уг салбар анх удаа ашигтай ажилласан байдаг. Гэтэл МАН 2016 онд УИХ дахь олонх болж, мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлж эхлээд 2,6 жил өнгөрөхөд Монгол улсын нийт өрийг 4 тэрбум ам.доллар, Засгийн газрын өрийг 4 их наяд 471 тэрбум төгрөг, 1 долоо хоногтой Төв банкны үнэт цаасыг 4 их наяд 554 тэрбум төгрөгөөр тус тус нэмжээ. Энэ нь тухайн үеийн Чингис бондоос даруй 4-5 дахин их хөрөнгө бөгөөд ийм их хэмжээний санхүүжилтээр ямар бүтээн байгуулалт хийж, хэчнээн иргэнээ шинээр орон сууцанд оруулж, хэдэн километр зам тавьж, хэдэн хүнийг ажлын байраар хангасан талаар дэлгэрэнгүй тайлан ирүүлнэ үү?

Асуулгад улсын нийт гадаад өр, Засгийн газрын өр, Төв банкны үлдэгдэл зэрэг үзүүлэлтүүдийн 2016 оны 6 дугаар сараас хойших өссөн дүнг дурдаж, нийлбэр дүнгээр нь Чингис бондын хөрөнгөөс 4-5 дахин их өрийг Засгийн газар тавьж, зарцуулсан мэтээр дурдсан нь үндэслэлгүй бөгөөд өрийн бүртгэлийн талаар ойлголтын зөрүүтэй байна.

Өрийн удирдлагын тухай хууль болон Олон улсын валютын сангийн Төлбөрийн тэнцлийн 6 дугаар аргачлалын дагуу авч үзвэл Засгийн газрын өрийн бүрэлдэхүүн болох Засгийн газрын гадаад өр нь улсын нийт гадаад өрийн статистикт мөн адил хамаардаг тул энэхүү 2 үзүүлэлтийн өсөлтөөр улсын өр нэмэгдсэн гэж ойлгох нь буруу юм. Мөн Төв банкны үнэт цаас нь Монголбанкны зүгээс банкны системийн чөлөөт эх үүсвэрээр дамжуулан мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх үндсэн хэрэгсэл бөгөөд арилжаагаар бүрдүүлсэн эх үүсвэрийг төсвийн шинжтэй аливаа төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтын санхүүжилтэд зарцуулдаггүй болохыг дурдах нь зүйтэй.

Улсын нийт гадаад өр 2016 оны 6 дугаар сараас 2018 оны 9 дүгээр сарын хооронд нийт 3.6 тэрбум ам.доллараар нэмэгдсэний дотор Засгийн газрын гадаад өр 2.1 тэрбум ам.доллараар нэмэгдсэн. Энэхүү өсөлт нь Засгийн газрын зүгээс 2017 онд 600.0 сая ам.долларын "Хуралдай" үнэт цаас, 800.0 сая ам.долларын "Гэрэгэ" үнэт цаасыг арилжаалсантай холбоотой. Мөн 2012 онд арилжаалсан Монгол Улсын Хөгжлийн банкны 580.0 сая ам.долларын "Евро" үнэт цаас, 500.0 сая ам.долларын "Чингис" үнэт цаас болон 2015 онд арилжаалсан 1.0 тэрбум юанийн "Дим сам" үнэт цаас (161.2 сая ам.доллар)-ыг төсөв болон эдийн засаг, макро орчинд ямар нэг ачаалал, дарамт үүсгэлгүйгээр бүрэн төлж барагдуулсан. Хөтөлбөрийн зээлийн хүрээнд 706.0 сая ам.доллар, төслийн зээлийн хүрээнд 680.5 сая ам.доллар нийт 1,386.5 сая ам.доллар авч ашиглаж, 2015 онд төсвийн алдагдлын нөхөх зориулалтаар зээлсэн 250.0 сая ам.долларын Кредит Свиссийн арилжааны зээлийн 24.0 сая ам.долларын төлбөрийг оруулаад нийт 183.3 сая

ам.долларын гадаад зээлийн төлбөрийг төлж барагдуулаад байна.

Засгийн газрын зүгээс 2016 оны жилийн эцсийн байдлаар 22.3 их наяд төгрөг, ӨҮЦ-ээр ДНБ-ий 78.8 хувьд хүрээд байсан Засгийн газрын өрийн хэмжээг 2017 онд 22.8 их наяд төгрөг, ӨҮЦ-ээр ДНБ-ий 74.4 хувь, 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 21.1 их наяд төгрөг, ӨҮЦ-ээр ДНБ-ий 60.9 хувь болгон бууруулаад байна.

Улсын нийт гадаад өрийн статистик болон Засгийн газрын өрийн статистикийн уялдаа, шинээр нэмэгдсэн өрийн зориулалт, ашиглалтын дүн, эргэн төлөлт, Сайн хөтөлбөрийн хүрээнд гаргасан үнэт цаасны төлбөр, Төв банкны үнэт цаасны зориулалтын талаар мэдээллийг өмнө нь танаас 2018 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр ирүүлсэн асуулгын хариуд албан бичгээр дэлгэрэнгүй тайлбарлан хүргүүлсэн болно.

Компани хоорондын зээллэг, шууд хөрөнгө оруулалт Монгол Улсын нийт гадаад өрийн хэмжээг 2016 оны 6 дугаар сараас 1.6 тэрбум ам.доллараар нэмэгдүүлсэн нь Монгол Улсын нийт гадаад өрийн өсөлтийн 44.4 хувийг бүрдүүлж байна. Энэ нь экспортыг нэмэгдүүлж, эдийн засгийн хүчин чадлыг тэлэх хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт бөгөөд Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчин сайжирсан, зээлжих зэрэглэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Урт хугацааны нийгмийн өгөөжтэй хэдий ч хөрөнгө оруулалтаа нөхөх боломжгүй, санхүүгийн хувьд ашиггүй төслүүдийг өндөр хүүтэй, арилжааны нөхцөлтэй бондоор санхүүжүүлэх бодлогоос Засгийн газар татгалзаж, харин улсын төсвийн дотоод нөөц боломж, гадаадын нэн хөнгөлөлттэй, урт хугацаатай эх үүсвэрээр санхүүжүүлэх бодлого баримталж байна.

2017-2018 онд 731 км авто зам, 640 у/м гүүр ашиглалтад оруулаад байна. Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах, шинэ суурьшлын бүсүүдийг хотын төвтэй холбож, төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд олон огтолцлол бүхий уулзвартай Яармагын гүүр, Замын цагдаагийн ойролцоо баригдах гүүрэн гарц, Сонсголонгийн гүүр зэрэг томоохон төслүүдийг хэрэгжүүлж байна.

Засгийн газар ерөнхий боловсролын сургуулийг 3 ээлжгүй болгох, хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах зорилтыг тавин ажиллаж байна. Энэ хүрээнд 2017-2018 онд 33 сургууль, 32 цэцэрлэг, 20 эмнэлэг, 9 дотуур байрыг ашиглалтад оруулсан. Засгийн газрын хэрэгжүүлж буй эдийн засгийн зөв бодлогын үр дүнд 2016 оноос 2018 оны хооронд ажил хөдөлмөр эрхэлж буй хүний тоо 95 мянгаар нэмэгдэж, ажилгүйдэл сүүлийн 3 жилийн хамгийн бага түвшинд хүртэл буюу 6.9 хувь болж буурлаа. Улмаар дундаж цалин 17 хувиар өсөж 1 сая төгрөгт хүрсэн бол өрхийн орлого 25 хувиар өсөж 1 сая 168 мянган төгрөг болж, эдийн засгийн өсөлтийн үр шим иргэдэд хүрч эхэллээ.

Барилга, хот байгуулалтын салбарт: Тухайн орон нутгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан төлөвлөлт, барилгажилтийн зураг төсөл, хүчин чадалтай уялдуулж одоо байгаа болон шинээр баригдах нийгмийн барилга байгууламж, орон сууцны хорооллуудын дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, эх үүсвэрийг шинээр бий болгох зорилтын хүрээнд 2016 онд улсын төсвөөс 16.6 тэрбум төгрөгөөр 17 төсөл, Монгол Улсын Хөгжлийн банкны санхүүжилтээс 40.0 тэрбум төгрөгөөр 11 төсөл, 2017 онд 66.1 тэрбум төгрөгөөр 66 төсөл, 2018 онд 74.0 тэрбум төгрөгөөр 78 төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн.

Улсын хэмжээнд 2016-2018 оны байдлаар 2016 онд 15,616, 2017 онд 14,320, 2018 оны 11 дүгээр сарын байдлаар 10,554, нийт 40'490 айлын орон сууц ашиглалтад орсон. Өнөөдрийн байдлаар зах зээл дээр борлогдоогүй байгаа 5,833

айлын орон сууц байгаагаас дунд болон түүнээс бага орлоготой иргэдийн худалдан авах чадварт нийцсэн нэгж талбайн үнэ нь 1,800.0 мянган төгрөгөөс бага үнэтэй, 60 м²-аас доош талбайтай борлогдоогүй орон сууц 1701 нэг ширхэг байна.

Монгол Улсын Засгийн газар Олон улсын валютын сангийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т хамрагдсантай холбоотойгоор “Орон сууцны зээлийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоо бүрдүүлэх хөтөлбөр” буюу ипотекийн зээлийг Монголбанкнаас санхүүжүүлж, алдагдлыг мөнгө хэвлэж нөхөх ажлыг зогсоох шаардлага өгсөн. Нийгмийн зайлшгүй хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн уг зээлийг зогсоолгүйгээр зээлийн эх үүсвэрийг 2017 оноос эхлэн улсын төсөв болон Монголбанкны өмчлөл дэх “Ипотекийн зээлээр баталгаажсан бонд” /ИЗББ/-ийн эргэн төлөлтөөс санхүүжүүлэхээр шийдвэрлэж 2017 онд улсын төсвөөс 110.0 тэрбум төгрөг, ИЗББ-ийн эргэн төлөлтөөс 294 .0 тэрбум төгрөг санхүүжүүлж 6026 иргэнд, 2018 оны жилийн эцсийн улсын төсвөөс 118.0 тэрбум төгрөг, ИЗББ-ийн эргэн төлөлтөөс 191.2 тэрбум төгрөг, нийт 309.2 тэрбум төгрөгийг зээлийн санхүүжилтэд зарцуулж 4,676 зээлдэгчид жилийн 8 хувийн хүүтэй зээл олгосон байна. Энэ хэмжээ нь Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар 2018 онд 6 дугаар сард хийлгэсэн “Орон сууцны эрэлт, нийлүүлэлтийн судалгаа”-наас харахад 33 мянган иргэн зээл авах боломжтой гэсэн тоо хэмжээтэй харьцуулахад бага байгаа тул зээлийн санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байгааг үндэслэн эх үүсвэрийг нэмэгдүүлэх хувилбарыг боловсруулж Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулж, ЭЗБХ-ны 2018 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 35 дугаар тогтоолоор улсын төсөв болон ИЗББ-ын эх үүсвэрээс гаргах зээлийн хүүг 4 хувиас 1 хувь болгон бууруулж, үүссэн хүүгийн зөрүүнд арилжааны банкуудын эх үүсвэрийг татан оролцуулах хувилбарыг боловсруулж дэмжүүлсэн. Үүний дагуу 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн Засгийн газрын 369 дүгээр тогтоолоор 2019 онд улсын төсөв болон ИЗББ-ын эргэн төлөлтөөс нийт 300.0 орчим тэрбум төгрөг ипотекийн зээлд зарцуулах байсныг арилжааны банкуудын эх үүсвэрийг мөн татан оролцуулж 500-600 тэрбум төгрөгийг иргэдэд жилийн 8 хувийн хүүтэй олгох боломжтой болгож “Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн үйл ажиллагааны журам”-ыг батлуулсан. Ингэснээр 2019 онд 8000-9000 иргэнд жилийн 8 хувийн хүүтэй зээл олгох боломжтой болж байна.

Мөн ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөр бүрдүүлэх боломжгүй, зорилтот бүлгийн иргэдэд зориулан хэрэгжүүлдэг “Түрээсийн орон сууц хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, Засгийн газрын 2016 оны 169, 298 дугаар тогтоолоор “Төрийн орон сууцны корпораци” ТӨҮГ-ын газрын захиалгаар баригдсан орон сууцнаас 583 айлын орон сууцыг төрийн өмчийн түрээсийн орон сууцны санд шилжүүлсэн. Мөн шинээр “Төрийн орон сууцны корпораци” ТӨҮГ -ийн захиалгаар 2016 онд баригдаж эхлээд санхүүжилтийн асуудлаас болж зогсоод байсан 1562 айлын орон сууцны санхүүжилтийн асуудлыг Монгол Улсын Хөгжлийн банкаар дамжуулан санхүүжүүлэх шийдвэрийг Засгийн газрын 2018 оны 81 дүгээр тогтоолоор батлуулсан. Энэ ажлын хүрээнд Уаанбаатар хотын “Буянт-Ухаа 2” орон сууцны хорооллын 972 айлын орон сууц, Говь-Алтай аймгийн 120 айлын орон сууц, Хөвсгөл аймгийн 135 айлын орон сууц, Орхон аймгийн 315 айлын орон сууцны барилгуудыг гүйцээж, ашиглалтад оруулахад шаардагдах хөрөнгийг хөгжлийн банкнаас шийдвэрлэн ажиллаж байна. Энэ ажил дээр яам, Хөгжлийн банк, “Төрийн орон сууцны корпораци” ТӨҮГ нар гурвалсан гэрээ байгуулж, тус яамнаас барилга угсралтын гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байна. Эдгээр орон сууцнуудын гүйцэтгэлийн явц 95 хувьтай хэрэгжиж байгаа бөгөөд ашиглалтад

орсны дараа иргэдэд түрээслүүлэх болон хөдөө орон нутагт хямд өртгөөр борлуулах арга хэмжээг зохион байгуулна. Түүнчлэн гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд газраа чөлөөлсөн иргэдийн түр суурьшуулах орон сууцны асуудлыг шийдвэрлэхээр Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо, "Орон сууцны VII хороолол"-ын орчимд 1008 айлын орон сууцны цогцолбор төслийг БНХАУ-ын 350.0 сая юанийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр шийдвэрлэхээр болж, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Зам, тээврийн салбарт: Авто замын салбарт 2016 оноос хойш улсын төсөв, гадаадын зээл тусламж, концессын гэрээгээр нийт 32 чиглэлийн 1022,85 км хатуу хучилттай авто зам, 6 байршилд 702,33 у/м төмөр бетон гүүрийг барьж ашиглалтад оруулсан болно. Тухайлбал, Алтай-Дарви чиглэлийн 263 км хатуу хучилттай авто зам, Дулаанхааны 4 замын уулзвараас-Ерөө-Хүдэр сум хүртэлх 104.4 км хатуу хучилттай авто зам, Улаанбаатар хотоос Хөшигийн хөндийн нисэх онгоцны шинэ буудал хүртэлх 32 км хурдны авто зам, Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл"-ийн хүрээнд 106.6 км хатуу хучилттай авто зам, Цахир-Тосонцэнгэл чиглэлийн 127.1 км хатуу хучилттай авто зам, Сонгино-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 85 км хатуу хучилттай авто зам, Дархан-Эрдэнэтийн авто замаас Сант сум хүртэлх 17.2 км хатуу хучилттай авто зам, Дорноговь аймаг Замын-Үүд сумын нутагт Замын-Үүдийн шалган нэвтрүүлэх боомтын 9.6 км хатуу хучилттай авто зам, талбайн барилга, байгууламж зэрэг болно.

Одоогоор авто замын салбарт 2019 онд нийт 25 чиглэлийн 1207,45 км авто зам, 10 байршилд 761,8 у/м төмөр бетон гүүрийн барилгын ажил он дамжин хийгдэж байгаа бөгөөд шинээр 95 чиглэлийн 1041,44 км авто замын барилгын ажилд, 12 байршилд 823,8 у/м төмөр бетон гүүрийн барилгын ажлыг Монгол Улсын 2019 оны төсөвт тусган худалдан авах ажлыг эхлүүлээд байна.

Түүнчлэн 2019 оноос Улаанбаатар-Дархан-Алтанбулаг чиглэлийн 345 км авто зам, Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн 60 км авто замын их засвар, шинэчлэлтийн ажлыг эхлүүлэхээр төлөвлөөд байна.

Авто замын салбар нь жил бүр 7260 орчим байнгын ажлын байр, 1500 орчим түр ажлын байр бий болгон ажиллаж байна.

Аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбох ажил үргэлжлэн хийгдэж байгаа бөгөөд 2016 оноос хойш энэ чиглэлээр нийт 572,1 км авто замын барилгын ажил, 23 км авто замын их засвар, шинэчлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Одоогоор Дорнод аймгийн төвийг нийслэлтэй холбоод байгаа бөгөөд үлдсэн аймгууд болох баруун бүсийн 5 аймгийн төв нь 2019-2020 онд нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбогдох болно.

Автотээврийн салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлээр Төв аймгийн Лүн сумын нутаг дэвсгэрт "Урьхан-2", Баян-Чандмань сумын нутаг дэвсгэр Аглагийн хийд рүү эргэдэг уулзварт, Ховд аймгийн Дарви суманд авто замын дагуух үйлчилгээний барилга байгууламж, Хэнтий аймгийн Өндөрхаан суманд автобуудал, "АТҮТ" ТӨҮГ-ын хөрөнгөөр Дорноговь аймгийн Сайншанд суманд автобуудлын барилгыг барьж ашиглалтад оруулж үйл ажиллагаа нь эхлүүлээд байна. Дээрх автобуудал, барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулснаар нийт 100 гаруй иргэд ажлын байртай болсон.

БНСУ-ын Засгийн газрын 5.5 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 2016 онд "Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх төсөл"-ийг хэрэгжүүлж их багтаамжийн 43 автобус худалдан авч үйлчилгээнд ашиглаж байна.

Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 02-ны 122 дугаар тогтоолоор "МОН-30" загварын 2 ширхэг цахилгаан автобус үйлдвэрлэхээр шийдвэрлэсэн бөгөөд агаарын бохирдлыг бууруулах, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих зорилтын хүрээнд байгаль орчинд ээлтэй "МОН-30" загварын их багтаамжийн цахилгаан автобус 2 ширхгийг нийлүүлэх, туршилт хийх гэрээг "Монгол машин индустриал" ХХК-тай байгуулж 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр ашиглалтад авж, нийтийн тээврийн үйлчилгээнд нэвтрүүлэх талаар туршилт, судалгааны ажлыг эхлүүлсэн.

Гашуунсухайтын боомтын нүүрс тээвэрлэлтэд үүсээд байгаа хүндрэл бэрхшээлийг судалж үзээд нүүрсний тээвэрлэлтийг хилээр нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх, байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөлөл болон авто замын ачаалал, осол зөрчлийг бууруулах, тээвэрлэгч жолооч нарын ажиллах таатай нөхцлийг бүрдүүлэх зорилгоор "Авто зогсоолын цогцолбор" төслийг хэрэгжүүлэх шийдвэрийг Засгийн газрын 2018 оны 04 дүгээр сарын 18- ны өдрийн 101 дүгээр тогтоолоор шийдвэрлэсэн.

Үүний дагуу Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэр Гашуунсухайт боомтод "Түгээмэлтүмэн хишиг" ХХК 19 тэрбумын төсөвт өртөгтэй авто зогсоолын барилга байгууламжийг 2019 оны I улиралд, мөн Цогтцэций суманд "Шанх манинг" ХХК авто замын дагуух үйлчилгээний барилга байгууламжийн барилга угсралтын ахспаа эхлүүлж, 2019 оны II улиралд ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 321 дүгээр тогтоолоор баталсан "Төрөөс автотээврийн салбарт баримтлах бодлого"-ын баримт бичигт тээврийн хэрэгслээс хүрээлэн буй орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг 2021 онд 5%, 2026 онд 2%-иар бууруулахаар заасан бөгөөд энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд нийтийн тээврийн хэрэгслийг цахилгаан болон хийн түлшний хэрэглээнд үе шаттайгаар шилжүүлэх, дизель хөдөлгүүртэй автобус, ачааны автомашинд утааны шүүлтүүр суурилуулж, 2019 оны 05 дугаар сарын 15- наас эхлэн утааны шүүлтүүргүй тээврийн хэрэгслийг нийслэлийн авто замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх талаар арга хэмжээ авахаар ажиллаж байна.

Улаанбаатар төмөр замын гол замын их засварын ажлыг Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусган хэрэгжүүлснээр жил бүр 50 км, сүүлийн 3 жилийн хугацаанд нийт 150 км төмөр замын их засварын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах, өсөн нэмэгдэж байгаа тээврийн хэрэгцээг хангах зорилгоор "УБТЗ" ХНН-ийн дүрмийн санг нэмэгдүүлсэн хөрөнгийн эх үүсвэрээр 60 сая ам.долларын өртөг бүхий "Төмөр замын дохиолол хориглол, холбооны системийн зураг төсөл боловсруулах, нийлүүлэх, угсралт, суурилуулалтын төсөл"-ийг хэрэгжүүлж байгаа бөгөөд 2019 оны эхний байдлаар диспетчерийн төвлөрүүлэлт ба дохиоллын системийн угсралт 97%, технологийн шуурхай холбооны ажил 97%, тоон радио холбооны ажил 60%-тай хэрэгжиж байна. "УБТЗ" ХНН-д одоогоор нийт 15026 хүн ажиллаж байгаа бөгөөд салбарын яамны зүгээс төмөр замын тээвэрлэлтийг нэмэгдүүлж үр ашигтай, аюулгүй явуулахад анхааран ажилласны үр дүнд Монгол Улсын төмөр замын ачаа тээврийн хэмжээ 2018 онд 25.6 сая тонн болж түүхэн дээд амжилт тогтоогоод байна.

Азийн хөгжлийн банкны 5 сая ам.долларын буцалтгүй тусламж, 32,4 сая ам.долларын зээлийн санхүүжилт, улсын төсвийн 16,34 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт Бүс нутгийн логистикийн төвийг барьж байгуулан 2019 оны 1-р сард Улсын комисс байнгын ашиглалтад хүлээн авах ажлыг зохион байгуулж байна. Энэхүү төв ашиглалтад орсноор 200 гаруй ажлын байр шинээр бий болохоос гадна хоногт 620 вагон шилжүүлэн ачиж, боловсруулах боломжтой болж байгаа бөгөөд Монгол Улсын нутаг

дэвсгэрээр дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлэх, үр ашгийг дээшлүүлэх, царигийн ялгаатай төмөр замтай улсын хилийн боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх, холимог тээврийг хөгжүүлэхэд ихээхэн түлхэц болох юм. Мөн Монгол Улс Ази- Европыг холбосон бусад тээврийн коридоруудтай өрсөлдөх таатай боломж бүрдэж байгаагаас гадна Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридорын хөгжил, арилжаа худалдааны эргэлт сайжрахад маш чухал хувь нэмэр үзүүлэх үндэс суурь болох юм.

Бүс нутгийн логистикийн төв нь 50 тн даацтай 2 ширхэг гүүрэн кран, механизмын засварын төв, өргөн болон нарийн царигийн ачилт буулгалтын 11,5 км төмөр зам, логистикийн төв руу орох гарах төмөр замтай 2 түвшинд огтлолцох хүнд даацын тээврийн хэрэгсэл явах боломжтой 19 у/м бетон гүүрэн байгууламж, 1,6 км авто зам, дэд бүтэц, барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ бүхий нийт 128 гат албайг хамарсан цогц байгууламж юм. Мөн тус төвийн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд гаалийн агуулах, захиргаа, жолооч ажилчдын байр, 3200 ширхэг контейнерийн багтаамжтай талбай, нийт 133 том оврын автомашины зогсоол зэрэг барилга байгууламжууд, камерын хяналтын их бүрэн систем, цэвэрлэх байгууламж, уурын зуух, усан санг барьж байгуулсан.

Япон Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Төв аймгийн Хөшигийн хөндийд олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг барьж ашиглалтад оруулаад байна. Энэхүү шинэ онгоцны буудал баригдснаар Монгол Улсын агаарын тээврийн хэмжээ нэмэгдэх бодит боломжийг бий болгож байна.

Нисэх онгоцны шинэ буудал нь жилд 3 сая зорчигч хүлээн авах хүчин чадалтай олон улсын стандартыг хангасан иж бүрэн цогцолбор бөгөөд том оврын агаарын хөлөг хөөрч, буух хоёр талын оролт, гаралттай зурвас, явгалах зам, перрон, нислэг, хөдөлгөөний удирдлагын байр, зорчигч үйлчилгээний барилга, захиргааны барилга, мөн түүнд холбогдох гүүрэн байгууламж, 825 авто машины зогсоол, 42 мегаваттын хүчин чадалтай дулааны станц, цахилгаан дамжуулах 110 Кв-ын өндөр хүчний шугамын дэд станц, гүний худгийн барилга, бохир ус цэвэрлэх ариутгах татуурга, ус цэвэршүүлэх байгууламж, агаарын хөлөгт үйлчлэх тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний барилга, гал унтраах, авран хамгаалах албаны барилга, 200 авто машины болон газрын үйлчилгээний тоног төхөөрөмжийн гарааж, ачаа, шуудан тээврийн үйлчилгээний барилга, агаарын хөлгийг шатахуунаар цэнэглэх газар доорх гидрант систем, нийт 8000 тонны багтаамж бүхий шатахууны агуулах сав, үерийн уснаас хамгаалах далан суваг, инженерийн шугам сүлжээний газар доогуурх 1,8 км урт цутгамал хонгил зэрэг 30 гаруй барилга байгууламжтай юм.

Орон нутгийн нислэгийн сүлжээг өргөжүүлэх, нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Хэнтий аймгийн “Өндөрхаан”, Увс аймгийн “Дэглий цагаан”, Говь- Алтай аймгийн “Алтай”, Завхан аймгийн “Доной”, Өмнө говь аймгийн “Гурван сайхан” нисэх буудлуудыг засварлан шинэчлэн сайжруулах ажил хийгдэж байна. Үүнд:

-Увс аймгийн “Дэглий цагаан нисэх онгоцны буудлын явгалах замын өргөтгөл”-ийн ажлыг эхлүүлсэн бөгөөд 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар нийт ажлын гүйцэтгэл 80%-тай байна.

-Говь-Алтай аймгийн “Алтай” нисэх онгоцны буудлын хөөрч буух хатуу хучилттай зурвас, үерийн далан байгуулах ажлыг хийж дуусгасан.

-Өмнөговь аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчлэх, 4D ангиллын хүчин чадалтай олон улсын нөөц нисэх буудал болгох зураг төсөл боловсруулах ажлыг тус тус хийж байна.

Авто замын салбарт 2016 оноос хойш барьж ашиглалтад оруулсан авто зам гүүрийн жагсаалт

№	Гэрээний нэр	Хүчин чадал	Гүйцэтгэгч	Ашиглалтад оруулсан огноо
1	Улаанбаатар-Баянчандмань чиглэлийн 6.1 км авто замын ээлжит засварын ажил	6.1 км	"Баянчандмань-АЗЗА" ТӨХК, "Беринг" ХХК	2016.08.20
2	Мандалговь-Даланзадгад чиглэлийн 163 км хатуу хучилттай авто замаас салаалсан хатуу хучилттай авто замын үргэлжлэл 5.204 км авто зам	5.204 км	Шинжиан Констракшн Инженеринг ХХК	2016.03.02
3	Өндөр довын уулзвараас-Жуулчны бааз хүртэлх 4.3 км хатуу хучилттай авто замын ээлжит засвар	4.3 км	"Ялгуусан" ХХК	2016.03.03
4	Яармагийн товчоо-Түргэний голын гүүр чиглэлийн 8.6 км хатуу хучилттай авто зам	8.6 км	"Ялгуусан" ХХК	2016.03.03
5	Төв замаас Городок тосгон хүртэлх 1 км хатуу хучилттай авто зам	1 км	"Анандын зам" ХХК	2016.07.21
6	Хөшигийн хөндийн олон улсын шинэ нисэх буудлыг Өндөрдовын жуулчны баазтай холбох 3.8 км хатуу хучилттай авто зам, Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замыг Өндөрдов жуулчны баазтай холбох 5.1 км хатуу хучилттай авто зам	8.9 км	"Ялгуусан" ХХК	2016.10.05
7	Хөвсгөл аймаг Мөрөн сумын доторх дунд тойргийн 9.8 км хатуу хучилттай авто зам	9.8 км	"Хотгор зам" ХХК	2016.12.19
8	Завхан аймаг Улиастай сумын 5.2 км хатуу хучилттай авто зам	5.2 км	"Төгс зам" ХХК	2016.11.28
9	Орхон аймаг Дэнж багт баригдсан 1.5 км хатуу хучилттай авто зам	1.5 км	"Сэлэнгэ есөн эрдэнэ"Х	2016.12.28
10	Орхон аймаг Баян-Өндөр сум, Говил баг 4.117 км хатуу хучилттай авто зам засвар, шинэчлэлтийн ажил	4.117 км	"Жавхлан харгуй" ХХК	2016.12.28
11	Сэлэнгэ аймаг Мандал сум Түнхэл тосгон Хараа голын 72.85 у/м төмөрбетон гүүр	72.85 у/м	"ЗМЗ" ХХК	2016.10.12
12	Увс аймаг Ховд сум Шивэрийн голын 72.80 у/м төмөрбетон гүүр	72.80 у/м	"Эйч Кэй Би" ХХК	2016.11.25
13	Сэлэнгэ аймаг Мандал сум чиглэлийн 15.8 км хатуу хучилттай авто зам	15.8 км	"Замын битум" ХХК	2016.05.09

14	Сэлэнгэ аймаг Дулаанхааны 4 замын уулзвараас Ерөө-Хүдэр сум чиглэлийн хатуу хучилттай 95 км авто замын 25 км хатуу хучилттай авто зам	25 км	Ерөнхий гүйцэтгэгч "Пик девелопмент" ХХК, Туслан гүйцэтгэгч "Мотор сервис" ХХК	2016.07.06
15	Дорнод аймгийн Матад сумын V хэсгийн! Тосон-Уул XIX талбайгаас Баянхошуу боомт чиглэлийн 210.7 км авто замын 1, II хэсгийн 104 км хатуу хучилттай авто зам	104 км	"Ди Кю И" олон улсын барилга угсралтын компани, туслан гүйцэтгэгч "Арж капитал" ХХК	2016.12.22
16	Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо, Хонхор тосгоны хатуу хучилттай авто зам	1.79 км	Өсөх-Урам ХХК	2017.01.31
17	Алтай-Дарви чиглэлийн 98 км хатуу хучилттай авто зам	98 км	"Монгол ЛЗ зам гүүр" Х;	2017.03.31
18	Дорноговь аймаг Замын-Үүд сумын нутагт Замын-Үүдийн шалган нэвтрүүлэх боомтын 9.6 км хатуу хучилттай авто зам, талбайн барилга, байгууламж	9.6 км	БНХАУ-ын зам барилгын Тай Фа Шян ххк	2017.04.14
19	Дархан-Эрдэнэтийн авто замаас Орхон сум хүртэлх 5 км хатуу хучилттай авто зам	5 км	Пик девелопмент ХХК, туслан гүйцэтгэгч "Мотор сервис" ХХК	2017.07.31
20	Дулаанхааны 4 замын уулзвараас-Ерөө- Хүдэр сум хүртэлх 104.4 км хатуу хучилттай авто замын II хэсгийн хатуу хучилттай авто зам	40 км	Пик девелопмент ХХК	2017.07.31
21	Улаанбаатар-Дархан чиглэлийн улсын чанартай авто замын ПК196+000-ПК202+000 хооронд хийгдсэн 6 км ээлжит засвар	6 км	Дархан-АЗЗА ТӨХК	2017.08.29
22	Дархан-Эрдэнэтийн авто замаас Сант сум хүртэлх 17.2 км хатуу хучилттай авто зам	17.2 км	Пик девелопмент ХХК, туслан гүйцэтгэгч "Мотор сервис" ХХК	2017.08.29
23	Дулаанхааны 4 замын уулзвараас-Ерөө- Хүдэр сум хүртэлх 104.4 км хатуу хучилттай авто замын III хэсгийн хатуу хучилттай авто зам	30 км	Пик девелопмент ХХК, туслан гүйцэтгэгч "Мотор сервис" ХХК	2017.12.19
24	Жаргалтхаан-Чингис хот чиглэлийн 100 км хатуу хучилттай авто замын их засвар, шинэчлэлтийн 1 дүгээр хэсгийн 17 км авто зам	17 км	"Наранбулагхан" ХХК, "Анандын зам" ХХК-ийн түншлэл	2017.11.24
25	Алтай-Дарви чиглэлийн 165 км хатуу хучилттай авто зам	165 км	"Монгол ЛЗ зам гүүр" Х ^А	2017.12.08
26	Архангай аймгийн Тариат сумын Тэрхийн голын 217.1 у/м төмөрбетон гүүрийн их засвар шинэчлэл	217.1 у/м	"Хурдны зам" ХХК	2017.12.28

27	Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Ерөө голын 272.7 у/м төмөрбетон гүүр 1.4 км сайжруулсан хөрсөн зам	272.7 у/м	Тангүүр" ХХК, "ЗЗБ" ХХК-ийн түншлэл	2016.08.31
28	Тосон-Ууд-Баянхошуу чиглэлийн 201.8 км хатуу хучилттай авто замын 4 хэсгийн 52 км	52 км	"Арж капитал" ХХК	2017.12.28
29	Цахир-Тосонцэнгэл чиглэлийн 127.1 км хатуу хучилттай авто зам /100 км/	100 км	"Хурдны зам" ХХК	2018.03.29
30	Хөвсгөл аймгийн Ханх сумын Ханх-Монд чиглэлийн 23 км хатуу хучилттай авто зам	23 км	"Хөвсгөл зам" ХХК	2018.10.29
31	Төв аймгийн Зуунмод сумын 0.785 км хатуу хучилттай авто зам	0.785 км	"Замын битум" ХХК	2018.11.14
32	Баян-Өлгий аймгийн Өлгий сумын төвийн 4.5 км хатуу хучилттай авто зам	4.5 км	"Жол" ХХК	2018.11.14
33	Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын Галын голын 36.7 урт метр төмөрбетон гүүр	36.7 у/м	"ЗМЗ" ХХК	2018.11.27
34	Ховд аймгийн төвийн 4.312 км авто замын шинэчлэлтийн ажлын үлдэгдэл 3.784 км хатуу хучилттай авто зам	3.784 км	"Түм дэлгэрэх" ХХК	2018.11.27
35	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Дорнод аймгийн Баянтүмэн сумыг Мянганы замтай холбох 1.75 км хатуу хучилттай авто зам	1.75 км	"Чандмань тал" ХХК	2018.12.11
36	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Ховд аймгийн Мөст сумын Бооржийн голын 30.68 у/м төмөрбетон гүүр, 0.75 км хайрган хучилттай авто зам	30.68 у/м	Эйч Кэ Би Интернэйшнл Холдинг ХХК	2018.12.19
37	"Петро Чайна Дачин Тамсаг" ХХК-ийн захиалгаар баригдсан "Тосон-Уул XIX талбайгаас Баянхошуу боомт чиглэлийн 210.8 км авто замын барилгын ажлын төсөл"-ийн III хэсгийн 54.6 км хатуу хучилттай авто зам	54.6 км	"Арж капитал" ХХК	2018.12.19
38	Архангай аймгийн Их-тамир сумын төвийн 1.7 км хатуу хучилттай авто зам	1.7 км	"Анандын зам" ХХК	2018.12.20
39	Азийн хөгжлийн банкны МОН-3129 зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл"-ийн багц 1-1, Хашаатын даваа-Шурагын гүүр чиглэлийн 50 км хатуу хучилттай авто зам	50 км	"Чайна Хуаши Интерпрайзис" ХХК	2018.12.18

Асуулга 2. 2016 оны 6 дугаар сартай харьцуулахад ам.долларын ханш 685 төгрөгөөр суларч, АИ-92 бензин 350 төгрөгөөр, А-95 бензин 430 төгрөгөөр, А-80 бензин 375 төгрөгөөр, дизель түлш 736 төгрөгөөр тус тус нэмэгджээ. Энэхүү валютын өсөлт, шатахууны үнийн нэмэгдэл ард түмний амьдралд хэрхэн нөлөөлж буй талаар судалгаа гаргасан эсэх талаар. Таны удирдаж буй Засгийн газар энэ бүхэнд ямар арга хэмжээ авахаар төлөвлөж байгаа талаар:

Дотоод эдийн засгийн сэргэлт, гадаадын шууд хөрөнгө оруулалтын өсөлтөөс шалтгаалж тоног төхөөрөмж, машин механизмын импорт ихээр нэмэгдсэн ч экспортын хэмжээг 2018 онд түүхэнд байгаагүй өндөрт хүргэж чадсан. Худалдааны тэнцэл ашигтай гарч байгаа тул валютын ханшид нөлөөлсөн гэж үзэх үндэслэлгүй байна. Харин АНУ бодлогын хүүгээ өсгөж, худалдааны бодлогоо өөрчилсөнтэй холбоотойгоор дэлхий даяар хөрөнгө оруулагчдын сонирхол өөрчлөгдөж, дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал нэмэгдлээ. Энэ нь олон улсын зах зээлд ам.долларын ханшийг чангаруулж, хөгжиж буй орнуудын валютын ханш ам.долларын эсрэг ихээр суларч байна. Жишээлбэл, Дэлхийн банкны орлогын ангиллаар манай улстай ижил бүлэгт хамаардаг (lower middle income) орнуудын ханш 2016 оноос хойш ам.долларын эсрэг дунджаар 23.8 хувиар суларсан. Монгол Улстай адил түүхий эдээс ихээхэн хамааралтай орнууд болох Казахстан Улсын тэнгэ 10.5 хувь, Индонези Улсын рупи 8.6 хувь, ОХУ-ын рубль 3.1 хувь, Чили Улсын песо 0.2 хувь, Канад Улсын доллар 4 хувиар тус тус суларсан байна.

Өөрөөр хэлбэл, Засгийн газар гадаад валютын нөөцийг нэмэгдүүлж, төсвийг алдагдалгүй байлгах, Засгийн газрын өрийн хэмжээг бууруулах, төсөв мөнгөний бодлогыг зохистой уялдуулах замаар монгол төгрөгийн ханш огцом сулрах дарамтыг бууруулж байна. 2018 онд төгрөгийн дундаж ханш ам.долларын эсрэг 1.1 хувиар суларсан бол рублийн эсрэг 5.2 хувиар чангарсан байна.

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2012 оны 6 дугаар сараас 2016 оны 6 дугаар сар хүртэлх хугацаанд 48 хувиар унасан, гадаад валютын цэвэр нөөц -400 сая ам.долларт хүрч шавхагдан төгрөгийн ханш сулрах дарамт өндөр болсон, макро эдийн засгийн суурь нөхцөлүүдээ яаралтай засахгүй бол валютын ханшийн хямралд ч хүрэхээр нөхцөл бүрдсэн байсан. Манай Засгийн газар төсөв, санхүү, эдийн засгийн зөв бодлогыг тууштай хэрэгжүүлж, макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангалаа. Гадаад валютын албан нөөцийг 2.7 дахин нэмэгдүүлж 3.5 тэрбум ам.долларт хүргэснээр эрсдэл даах чадвар дээшиллээ.

Дэлхийн түүхий эдийн зах зээл дээрх газрын тосны үнэ ханш өссөнтэй холбоотойгоор ОХУ-аас манай улсад нийлүүлж байгаа газрын тосны бүтээгдэхүүний хилийн үнэ 2017 оны 3, 4 дүгээр улирлаас аажмаар нэмэгдэж ирсэн.

Олон улсын валютын сантай хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд Засгийн газрын 2017 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 207 дугаар тогтоол, Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 309 дүгээр тогтоолоор тус тус автобензин, дизель түлшний онцгой албан татварыг үе шаттайгаар сэргээн тогтоосонтой зэрэгцэн дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ 2017 оны 7 дугаар сараас тогтмол өссөн, Монгол Улсын мөнгөн тэмдэгт төгрөгийн ханш ам.долларын эсрэг суларсан зэрэг хүчин зүйлсийн нөлөөллөөр шатахууны жижиглэн борлуулалтын үнэд өөрчлөлт орох нөхцөл аажмаар бүрэлдэж эхэлсэн.

Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2018 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 13 дугаар тушаалаар батлагдсан “Шатахууны жижиглэнгийн үнийн бүрдэл, компаниудын ашиг, алдагдлын тооцоог судалж санал, дүгнэлт гаргах” үүрэг бүхий


ажлын хэсэг байгуулагдан үүсээд байгаа нөхцөл байдалтай уялдуулан шатахууны жижиглэнгийн үнийн бүрдэл, компаниудын ашиг, алдагдлын тооцоог судалж, санал дүгнэлт гаргах төрийн байгууллагуудын хамтарсан шалгалт хийж, аж ахуйн нэгжүүдийн шатахууны жижиглэн борлуулалтын үнэ нь өнөөгийн борлуулж буй дүнгээс давсан буюу алдагдалтай ажиллаж байгаа нь тогтоогдсон. Энэхүү нөхцөл байдал нь үйл ажиллагааны зардал өндөртэй импортлогч компаниудын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, шатахууны жижиглэн борлуулалтын үнэд өөрчлөлт оруулах зайлшгүй нөхцөл үүсээд байсантай холбоотойгоор Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 26 дугаар тогтоолоор А-80 болон Аи-92 маркийн автобензиний онцгой албан татварын хэмжээг "0"-лэн тус бүтээгдэхүүний жижиглэн борлуулалтын үнийн огцом өсөлтийг саармагжуулсан. Тус онцгой албан татварын зохицуулалтыг хийснээс хойш гадаад зах зээлийн үнийн хэлбэлзэл, валютын ханшийн өсөлтөөс хамаарч жижиглэн борлуулах үнэ 2018 оны 2 дугаар сараас хойш шатахууны төрөл, борлуулж буй бүс нутгаас хамааран литр тутамдаа 300 орчим /270-353/ төгрөгөөр нэмэгдсэн.

Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор "Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийг тогтворжуулах ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтарсан Зөвлөл"-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж, УУХҮ-ийн сайдаар ахлуулах болсон. Хамтарсан Зөвлөлийн үндсэн зорилго нь Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тухайн үеийн байдал, гадаад, дотоод зах зээлийн нөхцөл байдал, дэлхийн газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл, нөөц, нийлүүлэлт, импортын үнийн хөдөлгөөн, тулгамдаж буй асуудлууд зэрэгтэй гишүүд тодорхой танилцаж, нөхцөл байдлыг хамтран авч хэлэлцэн санал бодлоо солилцох, гарах гарцыг хайх, нэг ойлголцолд хүрэх, улмаар нэгдсэн шийдвэрт хүрч Хамтарсан Зөвлөлийн "Зөвлөмж" гарган Засгийн газар болон төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн холбогдох байгууллагуудад уламжилдаг.

2018 оны 5, 6 дугаар саруудад дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ огцом өссөнтэй холбоотойгоор шатахууны үнэ дахин нэмэгдэж эхэлснээр ОХУ-аас нийлүүлэгдэх шатахууны хилийн үнэ 2018 оны 6 дугаар сард тонн тутамдаа 46-61 гаруй ам доллароор өссөн. Энэхүү үнийн өсөлттэй холбоотойгоор "Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийг тогтворжуулах асуудлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтарсан зөвлөл"-ийн хоёрдугаар хуралдааныг 6 дугаар сард, гуравдугаар хуралдааныг 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулж, шатахууны жижиглэнгийн үнэд өөрчлөлт орох нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлуудын талаар хэлэлцсэн бөгөөд хуралдаанаас гарсан зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан.

Роснефть компаниас 2017-2018 онд импортолсон шатахууны үнийг төрөл тус бүрээр нь доорх график-д харуулав.

График. Роснефть компаниас 2017-2018 онд импортолсон шатахууны үнэ төрөл тус бүрээр (нэгж: ам.доллар/тонн)



Эх сурвалж: Роснефть компани

Дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ ОХУ, ОПЕК-ийн орнуудын газрын тосны олборлолтын бодлого болон олон улсын геополитикийн зөрчилдөөнөөс шалтгаалан 2018 оны эхнээс эхлэн өсч “Брент” маркийн газрын тосны хаалтын ханш 2018 оны 10 дугаар сарын 09-ний өдөр хамгийн оргил үедээ 85 ам.доллар/баррель болж байсан боловч 2018 оны 10 дугаар сарын дунд үеэс эхлэн газрын тосны үнэ буурч эхэлсэн. Үүнтэй холбоотойгоор ОХУ-ын “Роснефть” компаниас 2018 оны 12 дугаар сард нийлүүлэх газрын тосны бүтээгдэхүүний үнэ өмнөх сартай харьцуулбал тонн тутамдаа 82-148 ам доллароор буурч орж ирсэн нь сарын дунд үеэс жижиглэнгийн үнэд эерэгээр нөлөөлж, үнэ хямдрахаар байна. Харин энэ үед ам.долларын ханш 2643.69 төгрөг буюу 2018 оны эхний ханшнаас 218 төгрөгөөр нэмэгдсэн.

ОХУ-аас манай улсад нийлүүлж буй хилийн үнэ буурсантай холбогдуулан 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн Аи-92 автобензин улсын хэмжээнд 100 төгрөгөөр, 2018 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн 45-50 төгрөгөөр, нийт дүнгээр 145-150 төгрөгөөр буурч, одоо дунджаар 1840 төгрөгөөр борлуулагдаж байна.

Мөн ОХУ-ын “Роснефть” компаниас нийлүүлж буй АИ-92 автобензины 2019 оны 01 дүгээр сарын хилийн үнэ 531 ам.доллар болж, өмнөх сартай харьцуулахад тонн тутамдаа 86 ам.доллароор буураад байна. Иймд ОХУ-аас нийлүүлж буй хилийн үнэ дахин буурч ирсэнтэй холбогдуулан АИ-92 автобензиний жижиглэнгийн борлуулалтын үнийг 2019 оны 01 дүгээр сарын 15-наас эхлэн эхний ээлжид 100 төгрөгөөр буулгах шаардлагыг шатахуун импортлогч аж ахуйн нэгжүүдэд хүргүүлээд байна. Ингэснээр Монголын хэрэглэгчдэд төвийн бүсээр борлуулах АИ-92 автобензиний жижиглэнгийн үнэ 1740 төгрөг болох юм. Жилийн өмнө буюу 2018 оны 02 дугаар сарын АИ-92 автобензиний төвийн бүсээр борлуулах жижиглэнгийн үнэ 1788 төгрөг байсан болно.

Цаашид авах арга хэмжээний талаар:

УУХҮЯ-ны зүгээс газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг ханган ажиллах, олон талт эх үүсвэрээс бүтээгдэхүүн импортлох бодлогыг баримтлан ажиллаж байна. Цаашдаа ОХУ-ын Роснефть компанитай байгуулсан гэрээний зүйл, заалтыг дордуулахгүйгээр тогтвортой мөрдөх, экологийн ангилал өндөр буюу чанар сайтай шатахууны үнийн томъёололд худалдан авагч талд хөнгөлөлт үзүүлэх талаар яриа, хэлцэл хийх байр суурийг баримтлан ажиллаж

байна. Мөн БНХАУ-ын Чайна-Ойл компаниас шатахууны импортын тоо хэмжээг нэмэгдүүлэх, импортлох хилийн боомтын тоог нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

Ойрын хугацаанд шатахууны хангамж, үнийг тогтвортой байлгах зорилгоор аажмаар зах зээлийн зарчимд нь шилжүүлэх, онцгой албан татварын хуульд холбогдох нэмэлт өөрчлөлтийг хийх, цаг тухай бүрт нь онцгой албан татварын зохицуулалтыг тодорхой төвшинд хийж үнийн огцом хэлбэлзлийг саармагжуулж байх, мөн бусад санхүүгийн дериватив зах зээлийн асуудлыг судалж, холбогдох арга хэмжээг авч ажиллана. Цаашид доорх арга хэмжээг авч хэрэгжүүлэх болно. Үүнд:

- Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн дотоод эх үүсвэртэй болоход онцгойлон анхааран Дорноговь аймгийн нутагт баригдах газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрийн явц, газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх,

- Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг ханган ажиллах, олон талт эх үүсвэртэй байх бодлогыг баримтлан ажиллах, БНХАУ-ын "Чайна Ойл" компаниас Гашуун Сухайт-Ганц Модны боомтоор шатахуун импортлоход шаардлагатай хоёр улсын хоорондын олон улсын гэрээ хэлэлцээр, ачаа тээврийн маршрут, холбогдох журам, зөвшөөрлийн асуудлыг судалж, ажил хэрэг болгон цаашид Шивээ-Хүрэн, Ярантай, Бургастай зэрэг боомтуудаар газрын тосны бүтээгдэхүүний импортолж эхлэх нөхцөлийг бүрдүүлэх,

- Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн ОХУ-ын Роснефть компанитай байгуулсан гэрээний зүйл заалтыг тогтвортой мөрдөх, экологийн ангилал өндөр чанар сайтай шатахууны үнийн томьёололд худалдан авагч талд хөнгөлөлт үзүүлэх талаар төр засгийн хэмжээний холбогдох уулзалтуудад энэхүү байр суурийг илэрхийлэх,

- Газрын тосны бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл, цаашдын чиг хандлага, зах зээлийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах,

- Дотоодод борлуулж буй шатахууны үнийн огцом хэлбэлзлийг саармагжуулах зорилгоор онцгой албан татварын хувь хэмжээгээр шуурхай зохицуулалт хийх,

- Шатахууны үнийг тогтвортой байлгах зорилгоор санхүүгийн дериватив зах зээлийн асуудлыг судалж танилцуулах,

- Шатахууны экологийн ангилал, импортолж буй боомтоос нь хамааруулан татварыг ялгавартайгаар тогтоох зэрэг асуудлаар онцгой албан татварын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг болно.

Асуулга 3. Хэрэглээний үнийн индексээр илэрхийлсэн инфляц 2018 оны 11 дүгээр сарын байдлаар улсын хэмжээнд 8.1 хувь, Улаанбаатар хотод 9.3 хувьд хүрж нэмэгджээ. Энэ нь бага, дунд орлоготой иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлж буй талаар судалгаа гаргасан уу? Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 11 дүгээр сарын байдлаар 7.5 хувиар, өмнөх оны мөн үеэс 8.1 хувиар өссөн. Тухайлбал, манай хүнсний гол хэрэглээ махны үнийг Нийслэлийн статистикийн мэдээллээс харвал, 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар хонины ястай мах өмнөх долоо хоногтой харьцуулахад килограмм нь 3.77 хувь буюу 244 төгрөгөөр, үхрийн ястай мах 8.6 хувь буюу 633 төгрөгөөр, үхрийн цул мах 11.66 хувь буюу 1,067 төгрөгөөр, ямааны мах 10.2 хувиар буюу 500 төгрөгөөр тус тус нэмэгджээ.

Ийнхүү ганц долоо хоногт кг махны үнэ 244-1067 төгрөгөөр нэмэгдлээ. Гурилын үнэ өмнөх сараас бүгд 0.6-5.0 хувиар, цагаан будааны үнэ өмнөх

сараас 16.4 хувиар өссөн байна. Тиймээс бага, дунд орлоготой иргэдээ үнийн өсөлтөөс хамгаалах бодлого хэрэгжүүлэх үү?

Хэрэглээний үнийн индексээр илэрхийлсэн инфляци 2018 оны 11 дүгээр сард 8.1 хувьд хүрсэн ба нийт инфляцийн 1/3-ийг мах, шатахууны бүлгийн үнийн өсөлт бүрдүүлж байна. Инфляцийн 1.2 нэгжийг бүрдүүлж буй шатахууны бүлгийн үнийн өсөлтөд дэлхийн зах зээлд газрын тосны үнэ өссөн (ОПЕК-ийн орнууд үйлдвэрлэлээ бууруулсан, АНУ-аас Ираны эсрэг хориг арга хэмжээ авсантай холбоотой) нь голлох нөлөө үзүүлсэн. Махны бүлгийн үнийн өсөлтөд улирлын шинж чанартай эрэлтийн өсөлт, нөгөө талаас махны экспорт нэмэгдэж байгаа нь голлон нөлөөлж байна.

Дэлхийн зах зээл дээр газрын тосны үнэ өсөх үед Монгол Улсын Засгийн газраас АИ-80, АИ-92 автобензинд ногдох онцгой албан татварын хэмжээг “0” болгох зохицуулалтын арга хэмжээ авсан бол дэлхийн зах зээл дээр газрын тосны үнэ буурсантай холбогдуулан нефть импортлогч аж ахуй нэгжүүд А-92 шатахууны үнийг удаа дараа бууруулж байгаа ба цаашид ч олон улсын зах зээлийн хандлагыг даган бууруулахаар байна.

Засгийн газраас “Мах, сүүний анхдугаар аян”-ыг өрнүүлэн, малыг эрүүлжүүлэх, ОХУ, БНХАУ, Иран, Япон зэрэг орнуудтай мах, махан бүтээгдэхүүн экспортлох чиглэлээр олон удаа хэлэлцсэний үр дүнд махны экспортыг нэмэгдүүлсэн.

Махны үнийг татаас олгох зэргээр зах зээлийн бус аргаар зохицуулахаас илүүтэйгээр гадаад, дотоод эрэлт, бэлчээрийн даац, малчин өрхийн санхүүгийн хэрэгцээнд тулгуурлан сүргийн эргэлтийн бодлогыг бэлчээрийн даацад тохируулан зөв удирдах замаар зохицуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Нөгөө талаас эдийн засгийн өсөлттэй холбоотойгоор зах зээлд шинээр ажлын байр бий болж, дундаж давхаргын тоо нэмэгдсэний зэрэгцээ өрхийн орлогын өсөлт инфляциас давж бодитоор өссөн байна. /Хүснэгт 1-3/ Түүнчлэн, махны үнэ өсөлттэй байгаа нь малчин өрхүүдийн мөнгөн орлогыг нэмэгдүүлж байна.

Засгийн газраас 2019 онд тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлж, эмч, багш нар болон бусад төрийн албан хаагчдын цалинг 8-30 хувиар өсгөнө. Бүтээн байгуулалтыг дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлэх хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3.2 их наяд төгрөгийг зарцуулна.

Хүснэгт 1. Өрхийн орлогын өөрчлөлт, дүнд эзлэх хувиар орлогын өөрчлөлт, дүнд эзлэх хувиар

Мөнгөн орлогын бүлэг	2016-111	2017-Ш	2018-111	Аанцлалт 2018.111/2016.111
Бүгд	100%	100.0%	100.0%	-
Бага орлоготой бүлэг 300 000 төгрөг хүртэлх	14.4%	13.7%	8.5%	-5.9
300 001-500 000	17.8%	15.6%	14.3%	-3.5
500 001-700 000	18.0%	17.4%	15.5%	-2.5
700 001-900 000	13.7%	14.0%	13.6%	-0.1
Личлаас лээш орлоготой бүлэг				
900 001-1 100 000	11.0%	9.8%	11.6%	0.6
1 100 001-1 300 000	15.6%	16.5%	19.5%	3.9
1 300 001-1 600 000	5.8%	7.3%	7.7%	1.9
1 600 001 төгрөгөөс дээш	3.7%	5.7%	9.3%	5.6

Эх үүсвэр: Үндэсний Статистикийн хороо

Хүснэгт 2. Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагсдын тоо, өрхийн сарын дундаж орлого

Үзүүлэлт	2016-111	2017-111	2018-111	2018.111/2016.111
Ажилчдын тоо /мян. хүн/	1,144.4	1,190.9	1,238.9	8.3%
Өрхийн сарын дундаж орлого /мян.төг/	937,1	1,018.6	1,168.5	24.7%

Эх үүсвэр: Үндэсний Статистикийн хороо

Хүснэгт 3. Ажиллагсадын цалингийн өөрчлөлт, дүнд эзлэх хувиар
Цалин хөлсний бүлэг

	2016411	2017411	2018-111	Өөрчлөлт 2018 111- 2016.111
Бvгл	100%	100.0%	100.0%	-
Бага цалинтай бүлэг				
192 001 төгрөг хүртэл	5%	2.5%	2.3%	-2.7
192 001-300 000	10.4%	11.2%	10.5%	-0.1
300 001-500 000	19.4%	17.8%	16.0%	-3.4
500 001-700 000	15.5%	19.8%	18.5%	-3.0
Дундаас дээш цалинтай бүлэг				
700 001-900 000	15.5%	16.2%	16.2%	0.7
900 001-1 100 000	10.4%	10.4%	11.3%	0.9
1 100 001-1 300 000	6%	6.2%	6.6%	0.4
1 300 001- 1 500 000	3.8%	4.2%	4.7%	0.5
1 500 001 төгрөгөөс дээш	9.9%	11.7%	13.9%	2.2

Эх үүсвэр: Үндэсний Статистикийн хороо

Түүнчлэн 2019 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн байдлаар үхрийн ястай мах 8500 төг, үхрийн цул мах 10000 төг, хонины ястай мах 6500 төг, адууны мах 7000 төг, ямааны мах 5800 төгрөгийн үнэтэй байна. /Хүчит шонхор зах/

Энэ нь 2018 оны мөн үетэй харьцуулахад, үхрийн ястай мах 22,2 хувиар, үхрийн цул мах 20.0 хувиар, хонины ястай мах 19.5 хувиар, адууны мах 27.5 хувиар, ямааны мах 37.3 хувиар, мөн 2017 оны мөн үетэй харьцуулахад, үхрийн ястай мах 17.9 хувиар, үхрийн цул мах 16.5 хувиар, хонины ястай мах 11.1 хувиар, адууны мах 34 хувиар, ямааны мах 25.8 хувиар тус тус өссөн дүнтэй байна.

Махны нөөц бүрдүүлэлт, нийлүүлэлт, хангамж, үнийн зохицуулалтын талаар авах арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Хүнс, хөдөө ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд байгуулан холбогдох арга хэмжээг авахаар ажиллаж байна.

Нийслэлийн хүн амын 2019 оны хаврын улирлын махны хэрэгцээнд зориулан арилжааны банкны зээлийн эх үүсвэрт хүүгийн хөнгөлөлт үзүүлэх замаар аж ахуйн нэгжүүдтэй хамтран махны нөөц бүрдүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд уг арга хэмжээг санхүүжүүлэхээр 2019 оны улсын төсөвт 4.6 тэрбум төгрөг тусгагдсан. Мал, мах бэлтгэлийн арга хэмжээний хүрээнд 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэр бүхий 7 аж ахуйн нэгжээс нийт 10.0 мянган тн мах бэлтгэж нөөцлөх талаар хамтран ажиллах хүсэлт ирүүлсэн байна. Энэ арга хэмжээний дүнд Улаанбаатар хотын 2019 оны хаврын улиралд махны хомсдол, үнийн хэт хэлбэлзлээс сэргийлэх нөхцөл, боломж харьцангуй бүрдэнэ.

Улаанбаатар хотын зах зээлд 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн байдлаар дээд гурилын үнэ дунджаар 1365 төг/кг болж өнгөрсөн оны мөн үетэй 1.0

хувиар нэмэгдсэн, харин 1 дүгээр гурилын үнэ 1060 төг/кг байгаа нь 1.3 хувиар буурсан дүнтэй байна. Монгол Улсын хүн амын 2019 оны хэрэгцээт гурилыг үйлдвэрлэхэд нийт 420 мянган тн улаан буудай шаардлагатай. Ургац хураалтын 2018 оны дүнгээс үзвэл нийт 428.6 мянган тн улаан буудай хүлээн авсан тул дотооддоо гурилын хэрэгцээг бүрэн хангах нөхцөл, боломж бүрдсэн.

Цагаан будааны үнэ 2019 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн байдлаар 3265 төг/кг болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 23.1 хувиар нэмэгдсэн дүнтэй байна. Манай улс байгаль, цаг уурын нөхцлөөс шалтгаалан цагаан будааны хувьд импортын 100 хувийн хамааралтай. Иймд цагаан будааны үнэ нэмэгдэж байгаа нь гадаад валютын ханш өссөнтэй холбоотой гэж үзэж байна.

Асуулга 4. Хүний хамгийн үнэт эрдэнэ нь эрүүл мэнд юм. Хүн, амьтны эрүүл явах үндэс бол цэвэр агаараар амьсгалах явдал юм. Улаанбаатарын утаа Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын агаарын чанарын стандартуудаас 10-35 дахин хол давсан гэдгийг Дэлхийн Банк сануулж байгаа. Гэр хорооллын хүүхдүүдийн 30 хувь нь сүрьеэгийн далд халдвар тээж, 1-5 насны хүүхдийн уушги хамгийн их гэмтэж байгаа. Харин жирэмсэн эхчүүдийн 20- 27 хувь нь эрт болон хожуу үеийн хордлоготой, хотын хүн амын 23-24 хувь нь амьсгалын замын өвчлөлтэй байгаа. Иймд агаарын бохирдол нийслэлийн иргэдийн эрүүл мэндэд ямар нөлөө үзүүлж байгаа талаар гаргасан тооцоо, судалгаа байна уу? Хэрэв байгаа бол Засгийн газар ямар арга хэмжээ авч, хор нөлөөг хэдэн хувьд хүртэл бууруулахаар төлөвлөж байна вэ?

Агаарын бохирдол нь хүний эрүүл мэндэд учирч байгаа орчны хамгийн том эрсдэл юм. Дэлхийн хүн амын 92% нь агаарын бохирдлоор Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж хэмжээнээс хэтэрсэн газар амьдарч байна. Агаарын бохирдол нь амьсгалын замын архаг өвчин, зүрхний өвчин, цус харвалт, уушгины хавдар зэрэг хамгийн их тохиолддог халдварт бус дөрвөн өвчний томоохон шалтгаан болж байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас дотоод орчны агаарын бохирдол нь өвчлөл үүсэхэд нөлөөлдөг ба дэлхийн нийт өвчлөлийн 2.7% нь дотоод орчны агаарын бохирдоос үүдэлтэй байгааг тогтоогджээ.

2012 онд ДЭМБ-ын тооцооллоор Монгол улсын гадаад болон дотоод орчны агаарын бохирдлын хавсарсан нөлөөллөөр үүссэн нас баралтын түвшин 100 000 хүнд 132 байгаа нь агаарын бохирдлын нөлөөлөл өндөртэй улс орнуудын нэгэнд тооцогдож байна (нас баралтын түвшингийн дэлхийн дундаж нь 100 000 хүнд 92 байна).

Олон улсын хавдрын агентлагаас 2013 онд агаарын бохирдол нь хавдар үүсгэдэг болохыг зарласан.

Агаарын бохирдол нь ургийн өсөлт, хөгжилтөд нөлөөлдөг гэдгийг АНУ, Канад, Польш, Норвеги, БНХАУ улсад судалж тогтоожээ. Түүнчлэн хөгжиж буй орнуудад хийгдсэн судалгаагаар гэрийн дотоод орчинд нүүрсний дутуу шаталтын дүнд үүсэх химийн нэгдэлүүд хүүхдийг бага жинтэй төрөх эрсдлийг 40 хувь нэмэгдүүлж, нярайн дундаж жинг 100 граммаар буурч байгааг тогтоожээ.

2018 оны хүйтний улирлын 12 дугаар сарын Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулагч бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад PM10 тоосонцор 18 мкг/м³-ээр буюу 8 хувиар, хүхэрлэг хий 12 мкг/м³-ээр буюу 28 хувиар тус тус их байсан бол PM2.5 тоосонцор 15 мкг/м³-ээр буюу 8 хувиар, азотын давхар исэл 10 мкг/м³-ээр буюу 16 хувиар бага байсан байна.

Улаанбаатар хотын сүүлийн 4 жилийн хүйтний улирал дахь гол бохирдуулагч бодис тус бүрийн сарын дундаж агууламжийг авч үзвэл,

- Агаар дахь PM10 тоосонцрын 2018 оны 12 дугаар сарын дундаж агууламжийг

- өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18 мкг/м-ээр буюу 8 хувиар их, Агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас 2.4 дахин их,
- Агаар дахь PM2.5 тоосонцрын 2018 оны 12 дугаар сарын дундаж агууламжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15 мкг/м³-ээр буюу 8 хувиар бага, Агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас 3.6 дахин их,
 - Агаар дахь хүхэрлэг хийн 2018 оны 12 дугаар сарын дундаж агууламжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12 мкг/м³-ээр буюу 28 хувиар их, Агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас 1.1 дахин их,
 - Агаар дахь азотын давхар ислийн 2018 оны 12 дугаар сарын дундаж агууламжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 мкг/м³-ээр буюу 16 хувиар бага, Агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжийн түвшинд байна.

2010 онд Дэлхийн банкнаас агаар дахь тоосонцрын агууламжийг өндөр хөгжилтэй улс орнуудтай харьцуулсан судалгаагаар Улаанбаатар хотын гэр хороололд хамгийн өндөр байгааг судалж, дэлхийд агаарын бохирдлоороо өндөр хот болохыг тогтоосон.

Улаанбаатар хотын агаарын PM2.5 тоосонцрын жилийн дундаж хэмжээ Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын агаарын чанарын удирдамжид заасан зөвлөмжөөс 7.5 дахин өндөр байна.

Агаарын бохирдол хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн талаар дараахь чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хийгдсэн байна. Үүнд:

- Хүүхдийн өвчлөлийн ерөнхий бүтцэд амьсгалын эрхтний өвчлөл нэгдүгээр байр эзэлдэг бөгөөд агаарын бохирдол ихтэй газар түүний эзлэх хувь нэмэгдэж байна. Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцроос үүдэлтэй өвчлөлд хүүхдийн уушгины хатгалгаа өвчин тэргүүлж байна.
- Гэр буюу энгийн галлагаатай сууцанд амьдарч буй хүүхдүүдийн дунд амьсгалын замын өвчний шинж тэмдэг орон сууцанд амьдардаг хүүхдийг бодвол илүү илэрч байна.
- Улаанбаатар хотын сургуулийн дотоод орчны агаар дахь PM2.5 тоосонцрын хэмжээ өндөр байгаа нь сурагчдын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх хэмжээнд байна.
- Сургуулийн сурагчид агаар дахь PM2.5 тоосонцрын өртөлтөд өглөө, оройн цагаар хичээлдээ ирж, очихдоо 9 дахин, сургууль дээрээ 3.3 дахин, гэртээ байх хугацаанд 2 дахин өртөж байна.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2013 онд хийсэн судалгааны дүнгээр 93 жирэмсэн эхийн ураг өсөлтгүй болсныг оношилжээ. Ургийн гаж хөгжлийг эрт үед нь оношлох зорилгоор 2013 онд тус төвд Ураг-нярайн эмгэгийг судлах төв /Перинатологи/, "Удам зүйн лаборатори байгуулж, 1.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж тоног төхөөрөмжөөр хангасан.

Түүнчлэн тус төвд нярай, 5 хүртэлх насны хүүхдийн төрөлхийн хөгжлийн гажууд, амьгүй төрөлт, нярайн эндэгдэл, эхийн эндэгдэл, ноцтой хүндрэл, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн идэвхтэй тандалтын тогтолцоог бүрдүүлж, 2014 оны 1-р сарын 1- нээс эхлэн улсын хэмжээний төрөлхийн хөгжлийн гажгийг бүртгэж мэдээлдэг болсон.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмч болон Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн багш нар агаарын бохирдол ургийн өсөлт, хөгжилтөд нөлөөлөх хүчин зүйл болж хүүхэд бага жинтэй эсвэл дутуу төрөх зэргээр нөлөөлж, хүүхдийн уушиг гэмтсэнээр насан туршийн эрүүл мэндэд нь сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй байгаа талаар дараахь судалгааг хийсэн байна Тухайлбал,

- D.Warburton нарын судалгаагаар өвлийн улиралд орчны агаарын хүхэрлэг хий (80г) агууламжийн хэмжээ нь ураг өсөлтгүй болохтой хамааралтай болохыг,
- Ө.Оюунчимэг нарын судалгаагаар жирэмсний явцад ургийн гаж хөгжил үүсэхэд агаарын бохирдол нь нөлөөлөх нэг хүчин зүйл болж байгааг, Д.Энхмаа нарын судалгаагаар өвлийн улиралд жирэмсэн эмэгтэйд хийсэн хэт авиан шинжилгээгээр ураг өсөлтгүй болж, зулбалт 3.6 дахин болж байгааг,
- Райн Аллен нарын судалгаагаар жирэмсний хугацаанд гэртээ агаар цэвэршүүлэгч ашигласнаар PM2.5 тоосонцрын агууламжийг 25 хувиар бууруулж, нярайн жинг 80 граммаар ихэсгэж, нярайн өндөр 0.4 см-ээр урт болсон талаар тус тус судалжээ.

Агаарын бохирдол хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд ачаалал, хүндрэл нэмэгдэн эрүүл мэндийн салбарт эдийн засгийн хохирол учирсаар байгааг Оксфордын бодлогын судалгааны хүрээлэнгийн эрдэмтэн нар манай орны судлаачидтай хамтран судалсан байна.

Агаарын бохирдлоос шалтгаалсан өвчний улмаас 0-18 насны хүүхдийг эмчлэхэд зарцуулсан шууд хохирлын хэмжээ 2016 онд 10.4 тэрбум төгрөг (4.8 сая ам.доллар) болсныг уг судалгааны дүнд дурьджээ. Хэрэв агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг эрчимтэй хэрэгжүүлэхгүй бол 2025 он гэхэд хохирлын хэмжээ 24.8 тэрбум төгрөг (9.8 сая ам. доллар) болж 2016 оны тооцооллоос даруй 2.3 дахин нэмэгдэх хандлагатай байгааг дээрхи судалгаагаар тогтоосон байна.

Калифорнийн их сургуулийн судлаачидтай хамтран хийсэн судалгаагаар PM2.5 тоосонцрын агууламжийг 200 мкг/м³-аар бууруулахад хүйтний улиралд амьсгал, зүрх судасны нас баралтыг 28 хувиар бууруулах боломжтой бөгөөд зуухнаас гарах утааны хэмжээг 80 хувиар бууруулахад агаар дахь PM2.5 тоосонцрын агууламж 48 хувиар буурч, жилдээ 66 сая ам.долларын эрүүл мэндийн зардлыг хэмнэх боломжтой болохыг судалсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 18 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу Нийслэлийн гэр хорооллын айл өрхийг сайжруулсан шахмал түлшээр хангаж агаарын бохирдлыг бууруулах зорилго бүхий “Таван толгой түлш” ХХК-ийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин компани хэлбэрээр өөрчлөн байгуулсан. Уг компанийн үйлдвэр 2018 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр нээлтээ хийсэн бөгөөд жилд 200 мянган тонн шахмал түлш үйлдвэрлэх хүчин чадалтай болно.

Мөн Засгийн газраас 2017 оны 98 дугаар тогтоолоор “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг, мөн Эрүүл мэндийн салбарын хэмжээнд уг ажлыг эрчимжүүлэх, ялангуяа хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллах, суралцах нөхцөлийг сайжруулах зорилгоор 2017 оны Засгийн газрын 225 дугаар тогтоолоор “Орчны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийг тус тус баталсан.

Түүнчлэн Хүний эрүүл мэндэд нөлөөлөх эерэг, сөрөг нөлөөллийг ажиглах, судлах, мэдээ, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, үнэлэх, мэдээлэх, хариу арга хэмжээг төлөвлөх үйл ажиллагааг зохицуулахаар Засгийн газрын 2017 оны 259 дүгээр тогтоолоор “Тандалт, судалгаа хийх журам”-ыг баталсан.

Ингэснээр хүрээлэн байгаа орчны бохирдлын гол үзүүлэлтүүдийг өвчлөлтэй нь холбон судалж, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулахаар “орчны эрүүл мэндийн тандалт, судалгааны нэгдсэн мэдээллийн санг” бий болгох ажлыг эхлүүлээд байна.

Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан “Уушгины хатгалгааны эсрэг вакцин”-ыг 2016 оноос эхлэн нийслэлийн дүүргүүдэд үе шаттай нэвтрүүлэх ажлыг зохион байгуулсан бөгөөд 2019 онд үндэсний хэмжээнд

нэвтрүүлнэ.

Эрүүл мэндийн яамнаас агаарын бохирдол ихтэй өвлийн улиралд бага насны хүүхэд, жирэмсэн болон хөхүүл эхчүүдийн дархлааг сайжруулах, ханиад, томууны дэгдэлтээс урьдчилан сэргийлэх зорилгоор Томуугийн эсрэг дархлаажуулалтад хамруулж, аминдэм, эрдсийн бэлдмэлийг түгээх ажлыг зохион байгуулж байна.

Агаарын бохирдлоос хүн амын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүнээс урьдчилан сэргийлэх талаар хийх сургалт, сурталчилгааг өргөжүүлэх, агаарын бохирдлыг бууруулахад иргэд, олон нийт, төрийн бус байгууллагын санал, санаачлагыг дэмжин ажиллаж байна.

Нийслэл Улаанбаатар хот төдийгүй аймгийн төвүүдэд агаарын бохирдол асуудал дагуулж, агаарын бохирдлын сөрөг нөлөөллийн улмаас эрүүл мэндийн байгууллагуудад нэмэлт ачаалал үүсгэж байна. Жил бүрийн улирлын томуугийн үед эмнэлэгийн ялангуяа хүүхдийн эмнэлгийн ор, эм, тариа хүрэлцэхгүй болж, ажилтнуудыг илүү цагаар ажиллуулдаг дүр зураг давтагдсан хэдий ч эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өөрсдийн нөөц бололцоог ашиглан шуурхай зохион байгуулж байна.

Түүнчлэн агаарын бохирдлоос хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах үүднээс Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын 2 дугаар улирлын амралтын хуваарийг "2018 оны 12 дугаар сарын 15-аас 2019 оны 2 дугаар сарын 15-ныг хүртэл хугацаанд тогтоох" саналыг "Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо"-нд тавьж, тус хорооны 2018 оны 10-р сарын 13-ны өдрийн 18 дугаар тогтоол гарч уг асуудлыг шийдвэрлээд байна.

Агаарын бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар хүн амын дунд мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх, олон нийтийн санаачилгыг дэмжих, агаарын бохирдлын сөрөг нөлөөллийг бууруулах, агаарын бохирдлоос үүдэлтэй өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх үүднээс 2018-2019 онд хэрэгжүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулан ажиллаж байна. Тухайлбал, 2018 онд өрх болон дүүргийн эрүүл мэндийн төв, сургууль, цэцэрлэгт 77 удаагийн сургалт, өдөрлөгийг зохион байгуулж, нийт 12806 хүнийг хамруулсан. Сурталчилгааг телевизээр 458 радиогоор 75, сонинд 74, вэб сайтаар 2341, пэйж хуудсаар 5000, 15 төрлийн цуврал инфографик, 6 төрлийн видео бичлэг, 50 гаруй мэдээ, мэдээллээр тус тус сурталчлан ажилласан.

Асуулга 5. Улсын төсөвт төрийн албан хаагчдын цалинг 8-30 хүртэл хувиар нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн ч өрсөөд инфляцид "идүүлчихлээ". Мөн валютын ханшийн өсөлт, шатахууны үнийн нэмэгдэл зэргийг тооцвол иргэдийн орлого асар их хэмжээнд буурлаа. Үүнд хамгийн ихээр нэрвэгддэг бүлэг бол бага, дунд орлоготой иргэд юм. Энэ тэгш бус байдлыг арилгах бодлого Засгийн газарт байна уу? Ард иргэдээ ажилтай, орлоготой байлгах төлөвлөсөн тодорхой ямар ажил байна вэ?

Засгийн газар иргэдээ ажилтай, орлоготой байлгахад чиглэсэн олон ажлуудыг 2019 онд хийнэ. Тухайлбал, бизнесийн орчныг сайжруулж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, татварын шинэчлэлийг хэрэгжүүлнэ. Төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлж, бодит салбаруудын өсөлтийг дэмжинэ. Төрийн албан хаагчдын цалин болон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг үргэлжлүүлэн нэмэгдүүлж, иргэдийн амьжиргааг сайжруулах замаар өрхийн хэрэглээг өсгөнө.

Эдийн засгийн өсөлтийг хангах, үр өгөөжийг нь иргэддээ хүргэх чиглэлээр Засгийн газар олон ажил хийлээ. Тухайлбал:

Ажилгүйдлийн түвшинг 2.2 нэгжээр бууруулж, өрхийн бодит орлогыг

нэмэгдүүллээ. Засгийн газрын хэрэгжүүлж буй эдийн засгийн зөв бодлогын үр өгөөж иргэдэд хүрч 2016 оноос 2018 оны хооронд шинээр 95 мянган ажлын байр бий болж, ажилгүйдэл сүүлийн 3 жилийн хамгийн бага түвшинд буюу 6.9 хувь болж буурч, энэ хугацаанд дундаж цалин 17 хувиар өсөж, 1 сая төгрөгт хүрсэн бол өрхийн орлого 25 хувиар өсөж, 1 сая 168 мянган төгрөг болсон байна.

Хүүхдийн мөнгөний хамрах хүрээг нэмэгдүүллээ. Өрхийн бодит орлогыг нэмэгдүүлж хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нийт хүүхдийн 80 хувьд, 2019 оноос хүсэлт гаргасан бүх хүүхдэд олгохоор шийдвэрлэлээ.

Төрийн албан хаагчдын цалинг үе шаттайгаар нэмэгдүүлж байна. 2018 оны 4 дүгээр улиралд төрийн албан хаагчдын цалинг инфляцийн түвшинтэй уялдуулан 8 хувиар нэмэгдүүллээ.

Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолоор ажлын байрны үнэлгээ, хөдөлмөрийн нөхцөл, инфляцийн түвшинтэй уялдуулан төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоолоо. Үүнээс эрүүл мэнд, боловсролын салбарын албан хаагчдын цалинг тухайн ажлын байрны үнэлгээ, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл зэргийг нь харгалзан, бага ангийн болон цэцэрлэгийн багш, эмнэлгийн сувилагч нарын цалинг 30 хүртэл хувиар нэмэгдүүлсэн.

Тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүллээ. 2018 онд Нийгмийн даатгал болон халамжийн сангаас олгож байгаа тэтгэвэр, тэтгэмжийг инфляцийн түвшинтэй уялдуулан нэмэгдүүллээ. Цаашид тэтгэвэр, тэтгэмжийг жил бүр нэмэгдүүлнэ.

Тэтгэврийн насыг сонголттой болголоо. Тэтгэврийн насыг эрэгтэй, эмэгтэй 65 байхаар нэмэгдүүлээд байсныг бууруулж ердийн нөхцөлөөр эмэгтэйчүүд 55, эрэгтэйчүүд 60 насандаа, мөн хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлөөр 45-55 насанд хүрсэн иргэн өөрөө хүсвэл тэтгэвэр тогтоолгох боломжтой болголоо.

Хувь хүний орлогын албан татварыг 4 шатлалтай болгоод байсныг нэг шатлалтай болгож, татварын хөнгөлөлтийн хэмжээг нэмэгдүүллээ. Цалингийн хэмжээнээс хамаарч 10, 15, 20, 25 хувь байсан хувь хүний орлогын албан татварыг шатлалгүй 10 хувь болгон бууруулж, улмаар татварын хөнгөлөлтийг орлогын түвшнээс хамаарч 240,000 төгрөг хүртэл нэмэгдүүллээ.

Орон сууцны Ипотекийн зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, үр нөлөөг сайжруулах нөхцөл бүрдүүллээ. Орон сууцны хөнгөлөлттэй зээлд 2018 онд нийт 309.2 тэрбум төгрөгийг зарцуулж, 4,676 зээлдэгчид орон сууцны зээл олгосон. Засгийн газрын 2018 оны 369 дүгээр тогтоолоор Засгийн газраас олгох эх үүсвэрийн хүүг бууруулж, банкны эх үүсвэрийг орон сууцны зээлд татан оруулах нөхцөл бүрдүүлэн, зээлийг шаардлага хангасан амины орон сууцанд олгох замаар агаар орчны бохирдлыг бууруулахад чиглүүлэхээр журамласан. Түүнчлэн, банкууд санхүүжилтийн эх үүсвэрийг өөрийн зорилгод нийцүүлэн ашиглах, зээлийн өргөдөл хүлээн авахаас үндэслэлгүйгээр татгалзах, зээлийн үндсэн төлбөрийг урьдчилан төлсөн тохиолдолд торгууль, шимтгэл ногдуулдаг байдлыг зассан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглүүлж байна. “Боловсролын үйлчилгээг тэгш, хүртээмжтэй болгох”, “Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, анги дүүргэлт хэт өндөр сургууль, цэцэрлэгийн ачааллыг бууруулж, 3 ээлжтэй сургуулийг 2 ээлжид бүрэн шилжүүлэх, Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн.

Татварын таатай орчин бүрдүүлэхээр ажиллаж байна. Бизнесийн орчныг

сайжруулах, хөрөнгө оруулалт, хөдөлмөр эрхлэлт, хөрөнгийн зах зээлийг дэмжих, зээлийн хүүг бууруулах, татварын суурийг өргөтгөх, татварын тэгш, шударга байдлыг бүрдүүлэх татварын шинэчлэлийн цогц бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Энэ чиглэлээр Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүд болон дагалдах бусад хуулийн төслүүдийг Засгийн газар Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна.

Асуулга 6. Улсын нэгдсэн төсвийн статистик дүнгээс харвал 2015 оны 11 дүгээр сард төсвийн орлого 5 их наяд 30 тэрбум, 2016 оны 11 дүгээр сард 5 их наяд 59 тэрбум төгрөг байжээ. Харин 2018 оны 11 сард 8 их наяд 228 тэрбум болж, даруй 3 их наяд 200 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ их хөрөнгөөр иргэдийнхээ амьдралд бодит тус дэм болох ямар бодлого хэрэгжүүлж, ямар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн талаараа тайлангаа ирүүлнэ үү?

Засгийн газар бага, дунд орлоготой иргэдийг үнийн өсөлтөөс хамгаалах зорилгоор ажлын байрыг нэмэгдүүлэх, зээлийн хүүг бууруулах, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх бодлого, арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Иргэдийн гарт ирэх цалин, хөдөлмөрийн хөлсний хэмжээг нэмэгдүүлэх, бага дунд орлоготой иргэдийн татварын дарамтыг бууруулах зорилгоор Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан УИХ-ын 2018 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан. Үүний үр дүнд 4 шатлалтай, 10-25 хувийн татварыг нэг шатлалтай 10 хувийн татвар болгож, иргэдийн орлогын түвшинтэй уялдуулан татвар төлөгч хувь хүний эдлэх албан татварын хөнгөлөлтийн хэмжээг 84.0 мянган төгрөгөөс 240.0 мянган төгрөг хүртэл нэмэгдүүлсэн.

Түүнчлэн, 2017 оны 4 дүгээр сард хуульд өөрчлөлт оруулж тэтгэврийн насыг эрэгтэй, эмэгтэй 65 байхаар нэмэгдүүлээд байсныг буцаан өөрчилж ердийн нөхцөлөөр эмэгтэй 55, эрэгтэй 60 насандаа тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх хуулийг санаачлан Улсын Их Хурлын 2018 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нийт хүүхдийн 60 хувьд олгож байсныг нэмэгдүүлэх зорилгоор "Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хамрах хүрээг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай" УИХ-ын 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 40 дүгээр тогтоолыг УИХ-аар хэлэлцүүлэн батлуулсан. Тогтоол батлагдсанаар хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нийт хүүхдийн 80 хувьд олгож хамрах хүрээг нэмэгдүүлэх эрх зүйн орчин бий болсон.

Асуулга 7. Экспортын орлого огцом өссөн, гадаад валютын зээл их хэмжээгээр орж ирсэн, аливаа гадны эдийн засгийн хориг байхгүй, эдийн засаг нь өсөлттэй, улс төрийн элдэв сонгуульгүй, дэд бүтцийн бүтээн байгуулалтгүй байхад Монгол Улсын өр нэмэгдэж, валютын ханшаа алдаж, инфляц нэмэгдсэн учир шалтгаанаа тайлбарлана уу.

Экспортын орлого өссөн, гадаад валютын нөөц нэмэгдсэн, аливаа гадны эдийн засгийн хориг байхгүй, эдийн засаг нь өсөлттэй, сайн байгаа гэдэг үнэн. Харин Засгийн газрын өрийг нэмэгдүүлээгүй, бууруулсан.

Засгийн газрын зүгээс 2016 оны жилийн эцсийн байдлаар 22.3 их наяд төгрөг, ӨҮЦ-ээр ДНБ-ий 78.8 хувьд хүрээд байсан Засгийн газрын өрийн хэмжээг 2017 онд

22.8 их наяд төгрөг, ӨҮЦ-ээр ДНБ-ий 74.4 хувь, 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 21.1 их наяд төгрөг, ӨҮЦ-ээр ДНБ-ий 60.9 хувь болгон бууруулаад байна. Олон улсын валютын сангийн хөтөлбөрийн хүрээнд авч буй урт хугацаатай, бага хүүтэй гадаадын хөнгөлөлттэй зээлийн ашиглалтын хэмжээ, валютын ханшийн нөлөөгөөр Засгийн газрын гадаад өрийн хэмжээ нэмэгдэж байгаа боловч Засгийн газрын зүгээс арилжааны нөхцөлтэй зээллэг аваагүй, өндөр хүүтэй дотоод үнэт цаас болон өрийн баталгаа гаргахыг зогсоосонтой холбогдуулан Засгийн газрын өрийн хэмжээ буурч, мөн хүүгийн зардал 2019 онд 865.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 285.1 тэрбум төгрөгөөр буурахаар байна. Засгийн газрын зүгээс Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь хэмжээг бууруулж, төсөвт учруулж буй өрийн үйлчилгээний дарамтыг багасгах бодлогыг үргэлжүүлэн хэрэгжүүлж байна.

Засгийн газраас валютын орох урсгалыг нэмэгдүүлэх хүрээнд хил орчмын нүүрсний экспортод тулгараад байсан гацааг улс төрийн түвшинд амжилттай шийдвэрлэлээ. 2018 онд 36.3 сая тн нүүрс экспортолж, экспортын орлого өмнөх оноос 13.4 хувиар өсөж 7.0 тэрбум ам.долларт хүрээд байна. Энэ нь түүхэн дэх хамгийн өндөр экспортын орлоготой жил болж байна. Харин АНУ бодлогын хүүгээ өсгөж, худалдааны бодлогоо өөрчилсөнтэй холбоотойгоор дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал нэмэгдлээ. Энэ нь ам.долларын ханш чангарч, хөгжиж буй орнуудын валютын ханш ам.долларын эсрэг ихээр сулрахад хүргээд байна. Монгол Улсын Засгийн газар гадаад валютын орох урсгалыг сайжруулж, нөөцийг нэмэгдүүлэх, төсвийг алдагдалгүй байлгах, Засгийн газрын өрийн хэмжээг бууруулах, төсөв мөнгөний бодлогыг зохистой уялдуулах замаар монгол төгрөгийн ханш огцом сулрах дарамтыг бууруулсан. 2018 онд төгрөгийн дундажханш ам.долларын эсрэг 1.1 хувиар суларсан бол рублийн эсрэг 5.2 хувиар чангарсан байна. Мөн ОУВС-гийн 6 дахь шатны үнэлгээгээр Монгол Улсын Засгийн газар макро эдийн засгийн эрүүл, зөв бодлого хэрэгжүүлсний үр дүнд хөрөнгө оруулагчдын итгэл сэргэж, эдийн засгийн өсөлт нэмэгдэж, зээлжих зэрэглэл сайжирсан гэж дүгнэсэн байна.

oooOooo